

ЕВРОП ДАХЬ МАНЖИЙН СУДЛАЛ

Волфганг Бауэр (*Wolfgang Bauer*)¹

Оршил

Манж судлал нь Манжийн ард түмний өвөрмөц түүхтэй холбоотой учир чухам юуг судалдаг вэ? гэдгийг хэлэхэд хэцүү байдгаараа манж судлалын шинж чанаруудын нэг нь болдог. Хэрэв бид манж судлалыг зөвхөн хэлний болон үндэсний уран зохиол талаас нь авч үзвэл түүнийг Түнгүс хэлний (манж хэл түүний өмнөд хэсэгт харьяалагддаг) бүлэгт буюу өргөн утгаараа бол Урал-Алтайн хэлэнд хамааруулах судалгаанд орох юм.

Энэ нарийвчилсан тодорхойлолтоор бол “Манж судлал” нь Хятад судлалтай ямар ч холбоогүй юм. Бүр эсрэгээр хэрэв манж судлал Манж угсаатанд харьяалагдах ард түмний соёл болон хэлийг судлах зорилго тавибал судлаачид хятаджсан манжуудыг бий болгосон сүүлийн гурван зуун жилийн хятадын соёлын хэсгээс судлахаас өөр замгүй болно.

Жишээлэхэд: “Улаан асарын зүүд” (*Hung-lou meng*) хэмээх романы зохиолчид болох Цао Чан (*Ts'ao Hsüeh- ch'in*), Као Е нар нь Манж гаралтай гэсэн үүднээс түүнд тулгуурлан судалгаа хийвэл учир дутагдалтай юм. Манж судлалыг Хятад судлалтай хослуулахад хэцүү бөгөөд манж судлалд хэл ч, түүх ч судлагдах тул Манж болон Хятад судлалыг салгаж бас болохгүй юм. Иймд бид дараах дүгнэлтэнд хүрлээ. Үүнд: Манж судлал нь манжийн ард түмний хэл, түүх болон соёлыг судалдаг ба тэдгээрийн анхны эхүүд нь манж хэлээр бичигдсэн (нутгийн эсвэл хятадаас орчуулсан) байдаг эсвэл өөр хэлээр (ихэвчлэн хятадаар) бичигдсэн, тухайлбал Манжийн түүхийг нэг болон өөр талаас нь харуулсан. Энэ тодорхойлолтоор цаашдын баримт эхэлж байна.

Судалгааны ажлын тулгуур болох Манж бичиг нь 1599 онд Монгол бичигт тулгуурлан зохиогджээ. 1632 оны үед нэмэлт тэмдгээр баяжигдсан байна. Энэ үед 12, 13-р зууны үеийн Зүрчин (*Jurchen*) удмынхан болох Манжийн 66 отог нэгдэж Хятадын зүүн хойд хилд дайсагнаж эхэлсэн байна. Тэд 1644 онд Бээжинг эзэлж Мин (*Ming*) улсын ноёрхлыг эцэс болгосон. Энэ нь Хятадын сүүлчийн ноёрхол байсан ба өөрсдийн Чин улсын ноёрхлыг тогтоожээ.

Соёлтой Хятадыг зэрлэг “Татарууд” ялсан явдалд Европ тун их харамсан энэхүү цоо шинэ гүрний тухай их зүйлийг мэдэх хүсэл төржээ. Ингэж Европчууд Манж судлалыг улс төртэй холбоотойгоор эхэлсэн боловч аажимдаа түүнээсээ чөлөөлөгдсөн

¹ Wolfgang Bauer(1995), *Manchu Studies in Europe*, Papers from an International conference on The History of European Sinology, Han-Shan tang Books, The Chiang Ching-kuo foundation, for International scholarly Exchange, p 419-437.

юм. Судалгаанд нэг талаас улс төрийн шийдэл нөгөөтэйгүүр онолын сонирхолын үүднээс хандаж байсан нь хоорондоо шууд болон шууд бус уялдаа холбоотой нь сүүлийн жилүүдэд ажиглагдсаар байсан. Европ дах манж судлалын хөгжлийг тодорхой 3-н үе шатад хувааж болох юм.

- Эхний шат нь 17-р зууны 2-р хагаст Манж Хятадыг байлдан дагуулсны дараахнаас эхэлж 19-р зууны дунд үе хүртэл үргэлжилдэг. Хятад Манжийн захиргаанд байсан энэ үе нь төв болон зүүн Азийн хойд хэсэг газар нутгаа тэлж байсан Оростой өрсөлдсөн хамгийн хүчтэй тэмцлийн үе байсан юм.

Ийм нөхцлүүд байсан учир манж хэлний мэдлэг хагас-дипломат харилцаанд чухал болох нь батлагдсан ба удалгүй энэхүү харилцаа хоёр орны хооронд бий болсон. Манж судлалыг Оросууд анх чухалчлан үзсэн бөгөөд тэндээс Европын бусад улсуудад түгэн дэлгэрсэн юм.

- Хоёр дах шат нь 19-р зууны 2-р хагасаас 20-р зууны эхний хагас хүртэл үргэлжилдэг. 20-р зууны эхний хагаст Манжууд Хятад дах ноёрхлоо хурдан алдаж эцэстээ Чин улсын ноёрхол бүрмөсөн унахад дахин мартагдсан.

Гэхдээ мөн үед тэдний хуучин нутаг болох Манжуурын бүсэд чухал хэрэг явдал болж Орос, Япон хоёр өрсөлдөн тэмцэлдэх болсон нь 1895 оноос хойш Японы сонирхож байсан Манжуур луу Орос Сибирийг дайрч өнгөрдөг төмөр замаа өргөтгөсөн явдал юм. Энэ нь 1904, 1905 оны Япон-Оросын дайнд хүргэж, Орос ялагдлаа. Японы Манжуурт хийсэн дараагийн алхмын оргил үе нь 1932 онд байгуулсан Манж го-гийн (*Man -chou -kuo*) тоглоомын засгийн газар байсан. Энэ нь Японд Манжийг зөвхөн онолын хувьд судлахад түлхэц болж удалгүй өндөр түвшинд хүргэснээс гадна европчуудын анхаарлыг ч татаж, энэ сэдвээр өргөн олны сонирхлыг татсан нилээд олон ном 1930-аад онд гарсан юм.

- Гурав дах шат нь БНХАУ-ыг тунхагласнаас өнөөдрийг хүртэлх үе юм. Манж судлал нь улс төрийн шууд нөлөөлөлд байхаа больсон. Манжчууд Манжуурын бүстэй адил улс төрийн тоглоом байхаа больсон.

Барууны эрдэмтэн мэргэд жинхэнэ эх сурвалжаас холдсон учир өөрсдийн номын санд хадгалагдаж буй Манжийн бичиг баримтыг хайж олохоос өөр боломж тэдэнд байсангүй. Тэд урьд өмнө хүний гар нэг их хүрээгүй ном зүйн талаарх судалгаа шинжилгээний ажилд анхаарлаа төвлөрүүлж одоог хүртэл ямар ямар сурвалжууд байгааг олж тогтоохыг чармайж байлаа. Ийм нөхцөл байдалд хөгжиж буй Манж судлал онолын талыг илүү барьсан ч нилээд нарийн чамбай ажил болсон байна. Анхны сурвалж бичгүүд одоо хүртэл архивт ч юм уу хаа нэгтээ нууцлагдаж байгаа үед Манж судлал улам бүр өргөжиж /зөвхөн Европод ч бус/ судлахад хялбар дөхөм болох юм. Европ дах манж судлал түүний хөгжлийн гурван үе шатыг доор товчхон өгүүлье.

Хятадыг байлдан дагуулагчдын талаарх мэдээ баримтын эрэлд /1650-1850/

Хятадын агуу эзэнт гүрэн урьд өмнө нэрийг нь ч дуулаагүй өчүүхэн Манжуудад эмгэнэлтэйгээр эзлэгдсэн явдал Европчуудыг мэл гайхууллаа. Хятадын эзэнт гүрнээс Манжийн эзэнт гүрэнд шилжсэн, хааны ордонд байр сууриа амжилттай хадгалж ирсэн Римийн котолик шашны элчүүдийн нэгнээс хамгийн анхны мэдээ иржээ. Энэхүү үйл явдал болон Манжийн эзлэн түрэмгийлэгчдийн талаарх анхны дэлгэрэнгүй баримтыг Римийн котолик шашны лам эцэг Мартино Мартини (*Martino Martini*) латин хэл дээр

“Татарын дайны тухай түүх” (*About the History of the Tartaric War*), (*De Bello Tartarico historia*) гарчигтайгаар бичсэн бөгөөд энэ нь 1654 оны эхээр Хятад Манжид бүрэн эзлэгдээгүй байх үед /уг номын дэд гарчиг энэ талаар дэлгэрэнгүй өгүүлдэг/ ажээ. Энэ бүтээл нь хэд хэдэн удаа хэвлэгдсэн бөгөөд тэр жилдээ Голланд, Франц, Герман, Англи, Португали, Испани хэлээр орчуулагдаж удалгүй Европын бусад /Скандиновын улсуудын/ хэл рүү орчуулагджээ.

Үүний дараа 1670 онд Хуан дэ Палафокс и Мендоса-гийн /*Juan de Palafox y Mendoca's*/ “Татарууд Хятадыг байлдан дагуулсны түүх” (*Historia de la Conquista de la China por el Tartaro*) хэмээх испани бүтээл гарсан нь франц, англи хэл рүү дахин орчуулагджээ.

Мөн сэдвээр П.Франсизко дө Рүжөман /*Francisco de Rougement*(1973)/ латин хэлээр, П. Адриан Грелон /*P.Adrien Greslon*/ болон П. Жозеф д' Орлеан /*P. Joseph d'Orleans*(1688)/ нар франц хэлээр бүтээл үргэлжлүүлэн бичсэн бөгөөд аажмаар хүрээгээ тэлсээр гагцхүү иезиутийн эцэг өвгөдийн гараар дамжин ирсэн.

Иезиутүүд улс төр, соёлын талаар бичдэгээрээ алдартай юм. Тухайлбал: Эзэн хаан Кан-Ши-гийн /*K'ang-shi*/ авд мордсон тухай П. Галлеото Перейра /*P. Galeotto Pereira*/, түүний аян замууд П. Фердинанд Вербейст /*P. Ferdinand Verbiest*–1684/, түүний сонирхдог зохиол П. Игнатюс Коиглер /*P. Ignatius Koegler*/, зан чанар болон түүхийн цаад шалтгааны тухай П. Жан Буве /*P. Jean Bouvet*–1697/ нар туурвиж байжээ. Бусад олон мэдээ захиагаар дамжин Ватикан болон бусад бичиг хэргийн хүрээлэнд ирсэн. Тэдгээрээс “Хятадын хэвлэмэл сонирхолтой захиа үсэг” (*Lettres edifiantes et curieuses de la Chine 1702–1776*) хэмээх нэртэй цуврал бүтээлд шилэн нийтэлсэн аж. Хожим тэдгээр бүтээлээс Ж.Б. Дю Алд-ийн /*J.B.du Halde*/ “Хятадын Түүх газарзүйн ерөнхий түүх...” Хятадын хаант засаглал болон Хятад Татаарын тайлбар (*Description of géographique, historique... de la Chine et de la Tartarie chinoise, 1735*) болон “Хятадын түүхийг хамарсан дурсамж бичиг” (*Memoires concernant l'histoire... des Chinois, 1776-1814*)–ийн цомог, Ж.Э.М. Мойриак дө Майа-гийн (*J.A.M.Moyriac de Mailla*) “Хятадын ерөнхий түүх” (*Histoire generale de la Chine, 1777-1785*) зэрэг бүтээлүүдэд иш татан ашиглажээ. Хятад дах Римийн католик шашны элч нарын байр суурь 1730 оноос доройтож 1773 оны үед өөр загвар сэтгэлгээ бүхий зохиолчид гарч ирснээр бүр мөсөн устсан байна. Энэ шинэ чиглэлийн хамгийн анхны бүтэлүүдийн нэг болох Францын эрдэмтэн Воже дө Брюнем-ийн (*Vojeu de Brunem*) бичсэн “Хятад улс Манж Татааруудад эзлэгдсэн түүх” (*Histoire de la conquekte de la China par les Tartares mandchous, 1754*) бөгөөд энэ нь олонд танил болсон гарчиг бүхий өмнөх бүтээлүүдийг дууриан хуулбарласан аж. Энэ ном 1788 онд оросоор орчуулагдаж гарсан нь орос хэл дээрх манж судлалын анхны бүтээлийн нэг болжээ. Дөрвөн жилийн өмнө Оросын хятад судлаач И.К.Росокин (*I.K.Rossokhin*) болон А.Л.Леонтьев (*A.L.Leont'ev*) нар 16 боть “Найман тугийн тэмдэглэл”-ийг (*Complete Record of the Eight Banners' /Pa- ch'i t'ung-chih/*) тайлбар тэмдэглэгээтэйгээр “Манж хүмүүс ба арми. Найман туг хийгдсэн гарал үүслийн ерөнхий тайлбар” (*A General Dscription of the Origin and Composition of the Manchu People and the Army, Made up Eight Banners' 1784*) гэсэн гарчигтай орчуулж гаргажээ. Тус хоёр эрдэмтний орчуулгад Манжийн элч Түлишэн (*Tulisen*)-ий 1712- 1714 он хийгээд 1724 онуудад Халимаг (*Kalmucks*) руу хийсэн аяны тэмдэглэл болох “Харь муж нутгийн тэмдэглэлүүд” (*Records of Strange Regions' /I-yü lu, 1764, 1782*) гэсэн гарчигтай зохиол багтдаг бөгөөд Түлишэн-ий үүрэг даалгавар Европын бусад орныхны сонирхлыг их татдаг. Түүнчлэн Их Чин гүрний хуулиуд (*The Statutes of the Great Chi'ng*

Dynasty) /*Ta- Ch'ing lü-li*/ хэмээх Леонтьев (*Leont'ev*)-ийн ганцаар орчуулсан 3 боть зохиол багтана. (1781–1783)

Сүүлийн энэ орчуулгад зохиолын манж гарчиг нь “Дайчин улсын бүгд хууль” (*Daicing gurun-i uheri kooli*) гэсэн гарчигт шууд дурдагдсан байна. Эдгээр орчуулгууд, түүнчлэн 17-р зууны сүүл үед холбогдох газар зүйн олон бүтээлүүд, аян замын тэмдэглэлүүд нь Их Петр хаан баруун болон төв Европтой соёлын дипломат холбоогоо чангатгаад зогсохгүй умард Азийн зүүн хэсгийг захирах болсноос хойш шинэхэн нээгдсэн Сибир лүү (1690 онд хэвлэгдэн гарсан Г.А.Шлайссин (*G.A.Schleissing*)-ы Герман хэвлэлд өгүүлсэн нь) олныг хамарсан сонирхлыг тусгажээ. Их Петр хаан (1682/89-1725) Өрнөд болон төв Европтой соёлын харилцаагаа бататгаж, хойт Азийн зүүн хэсгийг бүхэлд нь нэгтгэн захирах болсны дараа буюу 17-р зууны сүүлээр гарсан дээрх орчуулгууд болон Европын бусад хэл дээрх газарзүйн бүтээлүүд аян замын тэмдэглэлүүд “Шинээр нээгдсэн Сибирь”-ийг ихэд сонирхож байгааг тусгасан байдаг. Энэ явдал даруй өмнөд хэсгийг ноёрхож байсан Манжуудтай түнжин хагарахад хүргэсэн байна. Үүний улмаас дээр дурдсан Нерчинскийн (*Nerchinsk-1689*) гэрээ болон үүний дараа хиагтын гэрээ (*Kyakhta-1727*) байгуулагдахад бас түүнчлэн илүү чухал ч байж болох хоёр орны харилцааг зохицуулах зорилгоор Бээжингийн ойролцоо Оросын консул байгуулагдахад хүргэжээ.

Манжийн түүх соёлыг гүнзгий ойлгохын тулд хэлний мэдлэг зайлшгүй шаардлагатай байсан. Манж хэлний хамгийн анхны (олдвор бичиг) тодорхойлолтыг “Сонирхолтой захидал бичгүүд” (*Lettres édifiantes et curieuses*)-д хэвлэгдсэн Римийн католик шашны лам Парренин (*Parrenin*)-ы нэг захианаас олж болно.

Хамгийн анхны хэл зүй “Татаар хэлний элементүүд 1696 (*Elements of the Tartaric language, Elementa Linguae Tartaricae*) гэдэг ном латин хэл дээр зохиогчийн нэргүйгээр бичигдсэн бөгөөд энэ ном П.Ф.Вербист (*P.F.Verbiest*)-д илүү хамаармаар боловч ихэнх хүмүүс П.Ж.Ф.Жербильон (*P.J.F.Gerbillion*)-ыг бичсэн гэж үздэг.

Их эрдэмтэн Ж.П. Абел Ремюза (*J.P.Abel Rémusat*) энэ хэл зүйг франц хэл рүү орчуулсан нь хэвлэгдээгүй бөгөөд Хятадын тухай түүхэн дурсамжууд (*Memoires concernant l' Histoire des Chinois*)-д хэвлүүлсэн “Татар- Манжийн хэл зүй” (*Grammar of Tartar-Manchu 1787-88*) гэдэг бүтээлдээ Ж.М.Амьё (*J.M.Amiot*) ашигласан байна.

Түүнчлэн Ж.М.Амьё (*J.M.Amiot*) Манж-Хятадын толь бичигт үндэслэн (*Manchu-Chinese dictionary*) олон боть “Манж-Франц толь бичиг” (*Manchu-French dictionary 1789-1790*) зохиосон байна. Энд 2 жилийн өмнөхөн Л.М.Ланглын (*L.M.Langles*) /Амьё-гийн толь бичгийг редакторлосон/ хэвлүүлсэн Манж хэл эхлэн сурахыг хавсаргажээ. Мөн Амьё-гийн гар бичмэлүүдийг тухайлбал өөрийнх нь хэвлүүлсэн Манжийн ордны бөөгийн ёс заншлын тухай бичмэлийг оруулсан байна.

Манж хэлний мэргэжил нь Манж судлалаас түүх газар зүйгээс илүү ихээхэн онолын хандлагыг шаарддаг нь илэрхий юм. Энэ нь үнэндээ манж хэлний сонирхол нь зөвхөн практик тал биш гэсэн утга санааг агуулаагүй юм.

Жишээ нь: 1777 оны утга зохиолын шүүмжлэлд “Бээжин дэх иезуит Римийн католик шашны элчүүд эхлэн Манж хэлийг үздэг байсан бөгөөд энэ нь Хятад хэлийг бодвол хялбар байснаас гадна ихэнх хятад ном манж хэл рүү орчуулагдсан байсан” гэж тэмдэглэжээ.

Эртний үеийн Европын манж судлалын төв нь Франц байлаа. Иймээс ч 1814 онд Парист хятад, манж хэл, уран зохиолын анхны танхимыг үүсгэн байгуулжээ. Манж хятад хэл нь хэлшинжлэлийн үүднээс ялгаатай ч манж судлал болон хятад судлалыг эрт

үеэс нэгтгэн авч үзэж байсныг харуулж байна. Манж судлалд Франц хэл 18-р зуунд төдийгүй 19-р зуунд ч давамгайлж байсан бөгөөд хэлний болон үндэстнүүдийн саадыг туулахад маш чухал ач холбогдолтой байлаа.

Германы Х. Ж. Клапрот (*H.J.Klaproth*) 1804 онд Петербургийн академид дуудагдаж байсан ба хожим нь 1815 онд Парист ирж суурьшсан байна. Үүнд бид Манж утга зохиолын анхны судлал, Манжийн алдартай зохиолын дээжийн цуврал, Манж болон Хятад номнуудын жагсаалт болон гар бичмэл (Берлин дэх Royal номын сан /Paris, 1822)-ийг хамааруулж болох юм. Түүнчлэн Х.С.фон Габеленц (*H.C.von der Gabelentz*) гэгч герман хүн манж хэл зүй ба үг зүйн шинжилгээ судалгаа хийж “Манж хэл зүйн элементүүд” (*éléments de la grammaire mandchoue*, 1832) нэртэй анхныхаа номыг бичсэн. Уг номоо франц хэлээр бичсэн бөгөөд “Франц бол өнөө үед Манжийг хөгжүүлж буй цорын ганц орон юм” гэж дурдсан байна.

Англи хэл дээрх анхны Манж хэл зүй А. Вайл (*A.Wylie*)-ийн Манж-Хятадын хэл зүйн тухай орчуулга, Манж Татар хэлний тухай Хятад хэл зүй Манж утга зохиолын талаархи танилцуулга тэмдэглэлүүдийн хамтаар (*Translation of the Ts'ing Wan K'e Mung: a Chinese Grammar of the Manchu Tartar Language; with Introductory Notes on manchu Literature 1855*) зэрэг бүтээлүүд нь одоо хүртэл ашиг тустай хэвээр байна.

Алга болж байгаа иргэншлийн судалгаа

-1850- 1950-

19-р зууны Европын эрдэмтэд Манж хэлний талаар ул суурьтай мэдлэгийг олж авах гэж тэмүүлж байлаа. Манж хэл хятад хэлний ганц тал болон үхшимэл байдалтай болж үлдсэн нь үнэн болж байна. Манж хэл дээрх томоохон хэмжээний эх бичгүүд нь өдий хүртэл маш бага хэмжээгээр ашиглагдсаар ирж байна. Хятад хэлнээс орчуулсан болон хоёр хэл дээр байгаа асар их бүтээлүүдийн тоонд эдгээр эх бичгүүд тооцогддог билээ. Эдгээрийн ихэнх нь Манж хэлээр байгаа бүтээлүүд нь манжийн дээр үеийн утга зохиол, түүх засаг захиргаа, цэргийн баримт бичгүүд байдаг. Эх бичгүүдийн багахан хэсэг нь хэвлэгдсэн тул алга болох аюултай байсан. Үнэн хэрэгтээ хар тамхины (*Opium Wars*) дайн зогсож, 1842 онд Нанжины хэлэлцээрээр бий болсон Хятадын нээлттэй бодлоготой хамт гадаадын довтолгоон зэрэг нь ихээхэн аюултай байв. Мөн дотоодын бодлого ч аюул учруулж байлаа.

Энэ нээлтийн үр дүнгүүдийн нэг нь Европын сонирхол зүүн Сибирт өргөжиж, Амур-Усурын бүс нутаг, мөн Манжуур луу ч бас хандах болжээ. Зүүн хойд Азийн онцгой бүс нутгуудад хийсэн, албан ёсны, хагас албаны, хувийн зэрэг аялал жуулчлал, шинжилгээний ангиудын тухай ном зохиолын шинэ давалгаа энэхүү сонирхолын тусгал болж байв.

Зууны зааг дээр гарсан эдгээр ном зохиол нь араасаа “Манжуурын асуудал”-ын тухай олон өгүүллийг дагуулсан бөгөөд энэ нь эцэстээ Япон-Оросын дайнд хүргэсэн билээ. Эдгээр үйл явдлууд нь Европын Манж судлалд онц нөлөө үзүүлээгүй бөгөөд Манж Хятадын засгийн газар энэхүү зөрчилдөөнд ихээхэн залхаж байсан. Гэхдээ Европын Манжийн судлал дахь улс төрийн хөгжилтийн үр дүн нь чухал байсан бөгөөд зөвхөн Манжуурын газар зүйн мэдлэгээр хязгаарлаж байгаагүй билээ.

Манж гүрний удирдлагын сул тал нь өөрөө өөрийгөө хамгаалах боломжийг улам бүр доройтуулж энэ нь заримдаа олон нийтэд хүрэх боломжгүй байсан архивуудыг хүчээр нээхэд хүргэж байлаа. Дээр дурдсанчлан эх бичгүүд олноороо үрэгдэж байсан

аймшигт явдал нь заримдаа урьд өмнө орчин үеийн эрдэмтэд олж үзэх боломжгүй байсан сурвалж бичгийг илрүүлэх нөгөө талын бололцоог олгож байв. Иймэрхүү зүйлийн хамгийн их шуугиан тарьсан нээлт нь 1607-1632 болон 1635-1636 оны хоорондох Манжийн албан баримт бичгүүд байлаа.

Японы эрдэмтэн Найто Торажиро (*Naito Torajiro*) 1905 онд Орос-Японы дайн дуусч байх үед Японы сонины тайлбарлагчаар Мүгдэнд зочилж байсан бөгөөд тэрээр баримт бичгүүдийг анх нээсэн юм. Тэрбээр бас Чин улс мөхсөний дараахан 1912 онд “Манж бичгийн хуучин архив” (*Old archives in Manchu script*) /Үүнийг тэрбээр “*Man wen lao tang*” гэж нэрлэж байв/-ын зураг авах ажлыг эрхэлж байлаа.

Энэхүү “нээлт нь” /гэхдээ энэ нь эргэлзээтэй асуудал/ зөвхөн Япон төдийгүй дэлхийн Манж судлалын түүхнээ цагийг эзэлсэн үйл явдал болж өнөөдрийг хүртэл удаан хугацааны турш үнэлэгдсээр байна.

Манж хэл нь, соёл, улс төрийн хүч устаж үгүй болохын хамтаар манж эх зохиолуудыг олж тогтоох, хадгалах явдал улам бүр чухал болсныг энэ жишээ харуулна. Эдгээр эх бичвэрийг судлах шаардлагаар 19-р зууны 2-р хагаст Манж хэлний мэдлэг хэрэгцээ эрс өссөн байна.

Энэ үед Францын эрдэмтэн С. дө Арлез (*C.de.Harlez*) Манж судлалын янз бүрийн салбарт ажилласан нь нилээд үр дүнтэй болжээ. Тэрээр “Дорно Татарын үндэсний шашин” (*National Religion of the Eastern Tartars, 1887*), “Чин гүрний түүх” (*History of the / Jurchen / Chin Empire, 1887*) зохиолыг бичсэн ба “Зурхайт ном” (*Book of Change*)-ын Манж хувилбарыг Франц хэлнээ орчуулсан (1896-97) байна.

Үүнээс гадна “Манж хэлний гарын авлага” (*Manual of the Manchu language, 1884*) хэвлүүлсэн ба түүндээ 18-р зууны сүүлч үед эзэн хааны даалгавраар зохиосон агуу том бүтээл болох “Манж хэлний толь бичиг” (*Mirror of the Manchu language, манжаар Manju gisun-i buleku bithe*) зэрэг шилдэг бүтээлээс сонгон орчуулсан бөгөөд энэ нь гарын авлагын зорилгод маш сайн тохирсон болохыг Клапрот өөрийн бүртгэл (*Verzeichnis*)-дээ задлан шинжилжээ. Энэхүү “толь бичиг”-ийн “тоглоом наадгайн” хэсэг (*T'oung Pao, 1895-1901*) нэрээр Герман хэлээр орчуулж хэвлэжээ.

Толь бичгүүдийн дотроос Оросын эрдэмтэн И.И. Захаров. (*I.I. Zakharov*) “Манж-Орос бүрэн толь бичиг” (*Complete Manchu-Russian dictionary, 1875*)-ийг зохиосон бөгөөд дараа нь “Манж хэлний зүй” (*Manchu grammar, 1879*)-г хэвлүүлсэн нь манж судлалд шинэ хүрээ хэмжээг тотоожээ.

18-р зууны сүүл үеийн Манж-Орос хоёр ч толь гар бичмэлээр үлдэж хоцорчээ. Оросын зохиол бүтээлүүдэд алдарт хэл шинжлэлтэн болох А.О.Ивановскийн “Манж дээж бичиг” (*Manchu Chrestomathy, 1893-95*), А.М.Позднеевийн “Манж утга зохиолын дээжийг цуглуулсан туршлага” (*An Attempt toward a Collection of Specimens of Manchu Literature, 1904*) зэрэг бүтээлүүд нь Клапротын дээж бичгээс хол давуу болсон байна. Мөн түүнчлэн В.П.Васильев (*V.P.Vasilew 1863*), А.В.Гребеншиков (*A.V.Grebenshchikov*) /нэг нь 1909, нөгөө нь 1913 оны/-ын бүтээлүүд багтана.

19-р зууны сүүлчээс эхлэн Манж хэл шинжлэлийн судалгааны ажилд ялангуяа харьцуулсан хэл шинжлэлд Оросын эрдэмтэд манлайлж байна.

Тэд манж хэлний хэлзүй ба Оросын эзэнт улсын нутаг дэвсгэрийн зарим хэсэгт ярьж байсан Алтай язгуурын хэлний үгийн санг харьцуулан судлаж байснаараа давуу талтай. Эдгээр судалгааны ажлуудаас нэлээд үр дүнтэй зөвхөн ганц жишээг дурдахад Г.Д.Санжеевын (*G.D.Sanzeev*) “Манж-Монгол хэлний зэрэгцүүлэл” (*Manchus-Mongol*

linguistic Parallels, 1930) гэсэн бүтээл юм. Энэ нь судалгаанд нэлээд дөхөж очсон ба үүнээс гадна тэдгээрийн ихэнх нь Хятад хэл дээрх материалд тулгуурласан байдаг. Манж судлал нь Хятад судлалын туслах бөгөөд харин өөрийнхөө эрхийн хүрээнд Хятад дахь Манжийн ноёрхлын уналтыг тухайн үеийн өсөлтийг тусган харуулсан энэхүү дэвшил нь Орос төдийгүй Европын эрдэмтдэд ч хүрчээ.

Энэ шинэ үзэл бодол нь П.Шмидт (*P.Schmidt*)-ийн “Манж хэлэн дэх Хятад элемент” (*Chinese Element in Manchu* 1932-33) бүтээлд Хятад хэл нь туслах үүрэгтэй гэдгийг харуулахыг зорьсон юм. Энэ хандлага нь өнөөдөр хүртэл үргэлжилж байна. Гэтэл дээрхийн эсрэгээр, энэ үед Манж уран зохиолын хувьд жинхэнэ Манж эх зохиол дутагдалтай байснаас голчлон Хятад орчуулгаар л төсөөлж байлаа. Эдгээр нь дараах судалгаагаар илрэн гарна.

Л.Г.Мюллендорф (*P.G.Mollendorff*) “Манжийн уран зохиолын тойм” (*Essay on Manchu literature*, 1890), А.О.Ивановскийн (*A.O.Ivanovskii*) “Манжийн уран зохиолын түүхийн тойм” (*A Sketch of the History of Manchu literature*, 1893), А.В.Гребеншиковын (*A.V.Grebenshchikov*) “Манжийн уран зохиолын товч тойм” (*Brief Sketch of Manchu Literature*, 1909), В.Л.Котвичийн (*V.L.Kotvich*) “Манжийн уран зохиол” (*Manchu literature*, 1920) мөн Б.Лауферын (*B.Laufer*) “Манжийн уран зохиолын тойм” (*Sketch of Manchu Literature*, 1908) бүтээлүүд юм.

Б.Лауферын бүтээл нь нилээд чухал ажил болсон бөгөөд энэхүү бүтээлээ Унгарын “*Keleti Szemle*” /Мажарын хэл судлаачид тэдний хэл Урал-Алтайн хэлнээ хамаарна гэж үзэх болсон үеэсээ эхлэн Урал-Алтайн судалгааг сонирхсоор иржээ/-д хэвлүүлжээ. Энэ судалгаагаа дуусах үеэр Б. Лауфер АНУ-руу дүрэвсэн. Тэрбээр энэ үедээ Европын үндэстнүүдийн хувьд ганц нэг эрдэмтэн зарим асуудлыг шийдвэрлэхэд нилээд түвэгтэй гэдгийг олж мэдсэн ажээ. Гэхдээ энэ нь бусад Дорнод Азийн (*East Asia*) хэл соёлын судлалаас хамаарч байсан байж болох юм. Үүнтэй холбогдуулан 19-20-р зуунд шилжих үед Оросын хэл бичгийн шинжлэх ухаан Германы Манж судлалд нөлөөлж тодорхой ул мөрөө үлдээснийг дурдаж болох юм.

1890-1902 онд хэвлүүлсэн В. Банг-Каупын (*W.Bang-Kaup*) янз бүрийн өгүүлэл болон 17-18-р зууны үеийн Хятад дахь Манж нарын өвөг дээдэс болох “Зүрчидийн хэл, бичиг” (*Language and Script of the Jurchen*, 1896)-ийн тухай В. Грубегийн (*W.Grube*) номд энэ байдал илүү тусгалаа олсон байдаг. Тэрбээр мөн Герман-Манж томоохон толь бичиг зохиосон бөгөөд түүний бүтээл гэдгийг хүмүүс бүр хожуу ухаарч хэвлэн нийтлүүлсэн билээ. Үүнээс гадна тэр Хятадын философийн зохиолуудыг Манж хувилбараас нь Германаар орчуулсан нь Оросуудаас түрүүлсэн хэрэг байлаа. Энэ уламжлал нь Э. Хэниш (*E.Haenisch*), Э. Хауэр (*E.Hauer*) болон В. Фюц (*W.Fuchs*) нарын бүтээлд ч бас тусгалаа олжээ.

Э. Хэниш (*E.Haenisch*) бол Юань, Чин (*Yüan and Ch'ing*) гүрний түүхийн мэргэжилтэн байсан бөгөөд Манж хэлээрх түүхийн зохиолуудыг судлан хэвлүүлж байв. Тухайлбал тэрбээр Саган Сэцэний (*Secen Sagang*) “Монголын түүх” (*History of the Mongols*, 1933)-ийг Манж хувилбар болох, “*Mongyo han sai da sekiyen*” (*Die Mandschufassung von Von Secen Sagangs Mongolischer Geschichte*, 1933) ба “Горха-ийн тулалдааны өмнөх түүхийн тухай 1788 оны баримт бичгүүд” (*Documents from 1788 on the History of Before the Gorkha war*, 1959) хэмээх хоёр номыг орчуулсан байна. Тэрбээр хэл сонирхож “Бээжингийн ойролцоо Пи-юн-сэ” сүмийн үүслийн тухай 4 хэлний бичиг” (*The Quadrilingual Inscription on the Foundation of the Monastery Pi-yun-sze near Peking* 1924) хэмээх олон хэлний бичээсийн судалгааг нийтлүүлжээ.

Э. Хауэрийн (*E.Hauer*) эл хувь нэмэр нь “Манж гүрний үүсэл” (*The Foundation of the Manchu Empire*)-ийн тухай “Huang Ch'ing K'ai-kuo fang liao” хэмээх томоохон зохиолыг Хятад хэлнээс орчуулснаас гадна түүнийг нас барснаас хойш 20 жилийн дараа хэвлэгдсэн “Манж-Герман толь” (*Manchu German Dictionary 1952-55*) юм. В.Фюшц (*W.Fuchs*) 1930-1940 онуудад Хятадад 15 орчим жил сууж Манжийн утга зохиол судлалын байдлыг дээд түвшинд мэдэж авсан учраас номзүйн судалгаанд илүү их хувь нэмэр оруулсан хүн юм. Тэрбээр тухайн салбартаа баруунд, бараг эгнэшгүй үр бүтээлтэй ажиллаж байсан ном зүйч байсан бөгөөд Хятадаас Германд буцаж ирэхдээ хувийн номын сандаа олон арван ховор нандин Манж ном зохиолтой томоохон ном сонирхогч байжээ.

Тэрбээр түүхэн дэх Манж хэлний хамгийн том орчуулга болох “Манж Ганжуур” (*Manchu Kanjur*)-ын тухай судалгааны өгүүллийг 1930-32 онд хэвлүүлсэн байна.

1936 онд “Манж номзүй, утга зохиолын хувь нэмэр” (*Contributions to Manchu Bibliography and Literature*) хэмээх анхдагч бүтээлээ хэвлүүлж, 1942 онд үүндээ томоохон өгүүллийг дагалдуулсан байна. Үүнээс гадна тэр Чин улсын үеийн соёлын түүхийн талаар мөн Манжийн товч танилцуулгын нийтлэлүүдийг бичсэн. Эдгээр бүтээлүүд нь хэл шинжлэл ба түүхийн судалгаанд үнэтэйд тооцогддог юм.

В. Фюшийн Манж судлалын эрч хүчтэй хүчин чармайлт нь дэлхийн 2-р дайны дараа Европт бүхэл салбарт эрч хүч өгөв. Тэрээр М.Гимм (*M.Gimm*), Ж.Стари (*G.Stary*) зэрэг нэртэй эрдэмтдийн багш нь байв. Энэ хоёр эрдэмтдийн талаар хойно өгүүлэх болно. 1932 онд Японы санаачлагаар байгуулсан Манж-Го (*Man-chou-kuo*) улсын талаарх дэлхий дахины сонирхлыг тусгасан тэр нийтлэлүүд арай өөр чигийг баримталж байлаа. Тэдний цөөн хэд нь л шинжлэх ухааны үндэслэлтэй байсан ба улс төрийн энэхүү үйл явдал болон Манж судлалын хооронд шууд уялдаа холбоо байгаагүй билээ. Гэсэн ч зарим судлаачид олон нийтэд түүх соёлын үнэн зөв мэдээлэл хүргэхийг хичээж байсан. Тэдний нэг нь Францын эрдэмтэн Л.Жибер (*L.Gibert*) байсан бөгөөд түүний бичсэн “Манжуурын түүх газарзүйн толь” (*Historical and Geographical Dictionary of Manchuria 1935*) нь дан Хятад тулгуур бичигт үндэслэсэн хэдий ч Манж-Го-ийн түр оршин тогтнолын дараа ч үнэ цэнээ алдаагүй чухал бүтээл болсон юм.

Шинжлэх ухааны шинэ салбарт хүрэх замд (1950 оноос хойш)

Дэлхийн 2-р дайнаас хойш 4 жилийн дараа БНХАУ байгуулагдсаны үр дүнд Америк болон Европын ихэнх эрдэмтэд түүнчлэн Манж судлаачид Хятадыг орхин явах болжээ. Ажлынхаа дийлэнх хэсгийг ном зохиол судлал, хээрийн судалгаанд зориулдаг судлаачдын хувьд ажлын нөхцөл эрс өөрчлөгдсөн ба эдгээр шинжлэх ухааны салбар нь хамгийн ирээдүйтэй салбар болох байсан. Гэтэл Өрнөдийн эрдэмтдийн хувьд байдал санаандгүй өөрчлөгдөж, 19-р зууны дундуур Хятад улсыг нэгтэхийн өмнө байдал буцаж ирж ховор бичиг дурсгалд хүрэх боломжгүй болсон байна. Тэгээд тэд Тайвань дахь архив, номын сангийн Манж номын цуглуулгыг ашиглах болжээ. Тэнд хадгалагдаж байсан зарим номыг хэвлэн нийтэлж улмаар дэлхийн эрдэмтдийн хүртээл болгосон билээ.

Энэ салбарт болсон нэгэн чухал үйл явдал бол Тайпэй дэхь Хааны ордны музейд байсан “Манжийн хуучин архив” (*Old Manchu Archives*) хэмээх бичиг дурсгалыг 1969 онд нээн олж нийтэлсэн явдал юм.

17-р зууны үед хамрагдах эдгээр бичиг баримт нь 1905 онд Найто Торажиро (*Naito Torajiro*)-ийн олсон “Манж бичгийн хуучин архив” (*Old Archives in Manchu Script*)-ийн жинхэнэ эх нь байсан юм.

Эдгээр нь зөвхөн Тэнгэрийг тэтгэгчийн үе буюу 18-р зууны 2-р хагасыг хамарсан хожмын бичиг зохиолоос дусал бинтгүй эртний бичгийнхээ хувьд төдийгүй заримдаа утгаараа ч ялгарч байлаа.

Энэ хоёр сурвалжийг хослуулснаар мэдээлэл хэрхэн гарч ирсэн хийгээд Манж-Хятадын албан ёсны түүхэн бичигт бодит баримтыг хэрхэн албаар өөрчилснийг харж болох оновчтой хэрэглэгдэхүүн болжээ.

Энэхүү харьцуулалтын суурийг М.Вайерс (*M. Weiers*) ‘*Chiu-Man-Chou tan*’ болон ‘*Man-wen lao-tang*’ хоёрын баримт бичгийн тохиргоо 1620-1630”, (*Concordance to the Documents on the Chiu Man Chou tang and the Manwen laotang years 1620-1630, 1987*) гэдэг номдоо тавьсан юм.

Монгол судлаач М.Вайерс нь Монгол ба Манжийн хэл соёлын харилцааны талаар их дэлгэрэнгүй бичсэн. Дашрамд хэлэхэд, түүний “Тохиргоо” (*Concordance*) нь бүхэлдээ Манж судлалд зориулагдсан Герман Италийн “*Aetas Manjurica*” цувралын анхдугаар ботид анх гарсан бөгөөд одоогоор уг цувралын гуравдугаар боть хэвлэгдэж байгаа юм.

Энэ мэтийн ном зохиол хэвлэгдэж байсан хэдий ч Манжийн шинэ материалыг олж авах нь ерөнхийдөө ховор завшаан бөгөөд зарим тохиолдолд 30-аад жил үргэлжилсэн Хятадын тусгаарлагдмал байдлаас болж онц ахиц гарахгүй байлаа.

1822 онд Клапрот (*Klaproth*) Манж номын анхны каталогийг зохиосноос хойш Европ дахь Манж судлаачид өөрийн номын санд буй Манж номын цуглуулгын тухай дурсах аргагүй биз.

В.Фюш-ийн “Хятад Манж гар бичмэл болон барын ховор ном судар, Манж судлалын бусад бүтээлийн бүртгэл цэс” (*Chinese and Manchu Manuscripts and Printed Books, together with a Reference list of other Manchu works, 1966*), В.Симон (*W. Simon*) болон Х.Г.Нелсон (*H.G. Nelson*) нарын “Лондон дахь Манж ном” (*Manchu books in London, 1977*) зэрэг каталогууд шинэ жишгийг тогтоож өгсөн юм.

Орост М.П.Волкова (*M.P. Volkova*) “ЗХУ-ын ШУА-ийн Азийн ард түмний хүрээлэн (одоо Дорно дахины судлалын хүрээлэн)-гийн Манж гар бичмэлийн товчоо” (*Description of Manchu Manuscripts of the Institut naradov Azii (now Institut vostokovedeniya) of the Academy of Sciences of the USSR*)-г 1965 онд нийтлэв.

Үүний дараагаар 1988 онд тус хүрээлэнгийн Манж барын номын каталог ч хэвлэгдэн гарлаа. Хамгийн олон тухайлбал 12-оос доошгүй тооны каталогийг Х.Валравенс (*H. Walravens*) гаргасан юм.

Үүнд: “Парисын Хятад судлалын хүрээлэнгийн Манж бүтээлийн тойм” (*A Survey of Manchu Works in the Institut des Hautes Etudes Chinoises Paris 1976*), “Лейдений Хятад судлалын хүрээлэнгийн Манж ном зохиол” (*Manchu books in the sinologish Institut Leiden, 1986*) мөн “АНУ-ын номын сангууд дахь Манж ном зохиолын нэрийн урьдчилсан жагсаалт” (*A Preliminary Title-list of Manchu Books in the Libraries of the USA 1976*), “Тайпэй дахь үндэсний музей ордны Манж номууд” (*Manchu books in the library of the National Palace museum Taipei, 1987*) зэрэг каталогууд орно. Манж Тунгус хэлний харьцуулсан судалгаа хийхэд анхдагч материал заавал шаардагдахгүй.

Энд бас л Орос Унгарын эрдэмтэд тэргүүлсэн. Тухайлбал В.И.Цинциус (*V.I. Cincius*) голдуу Манж Монгол хэлний харилцааг судалж “Манж Тунгус хэлний харьцуулсан

толь” (*A Comparative Dictionary of the Manchu-Tungus Languages, 1975-77*)-ийг хэвлүүлсэн.

Л.Лигети (*L.Ligeti*) “XII зууны Манж-Тунгус бичиг: Зүрчидийн ‘бага’ бичээсийн тайлбар” (*A Manchu-Tungus Script of the 12th Century: An Interpretation of the ‘Little’ Jurchen Script, 1948*)-ыг бичиж, Урал-Алтайн судлалын салбар дахь нэн чухал цуврал болох “*Acta Orientalia Academiae Hungaricae*” сэтгүүлд “Манж бичгийн тухай” (*On the Manchu Script, 1952*) өгүүлэл нийтлүүлжээ. Дайны дараа Америкт очсон Унгарын Тунгус судлаач Д.Синор (*D.Sinor*) “Манж судлалын удиртгал” (*Introduction to Manchu Studies, 1954*), “Манж хэлний гарын авлага” (*Handy sketches of the Manchu language, 1968*), “Манж уран зохиол” (*Manchu literature, 1969*) зэрэг бүтээлээ хэвлүүлсэн байна.

Энэ сэдвийн хүрээнд Германы Г.Дөрфер (*G.Doerfer*)-ийн “Манж хэлний тоо” (*The number in Manchu, 1962*), “Монгол Тунгус судлал 1989”, Э.фон Менде (*E.von Mende*)-ийн “Манж шинэ гэрээний хэвлэлийн зарим тэмдэглэл” (*Some remarks on the Printed Editions of the Manchu New Testament, 1972*) зэрэг бүтээлийг дурдах хэрэгтэй.

М.Гимм (*M.Gimm*) голдуу Хятадыг судалдаг байснаа Манж судлалд нилээд өөр аргаар хандсан. Тэрээр “Манжаар хэсэгчлэн орчуулсан Хятадын Wen hsun-ы цоморлиг” (*The Chinese Wen hsun Anthology in Manchu Partial Translation, 1968*) “1685-86 оны хааны Ку-Вэн цоморлиг, Ку-Вен Юан-Шы Манж орчуулга” (*The Imperial Ku-wen Anthology of 1685-86: Ku-wen yuan-chien, in Manchu Translation*)-ыг хянан хэвлүүлж “Хятад тууж ба өгүүллэгүүдийн Манж орчуулга” (*Manchu Translations of Chinese Novels and Short Stories, 1989*)-ын талаар судалгаа хийсэн байна. Түүнээс гадна “Манжийн уран зохиол” (*The Literature of the Manchus, 1984*) хэмээх шинэ түүхэн танилцуулгыг мөн хэвлүүлэв. Орос дахь Манж гар бичмэлийн номзүйн хамгийн үр ашигтай бүтээл бол эрдэмтэн М.П.Волкова (*M.P.Volkova*)-гийн “ЗХУ дахь Манж цуглуулга” (*On the Manchu Collections of the Soviet Union, 1968*) хэмээх нарийвчилсан тэмдэглэл бөгөөд түүний “БНХАУ дахь манж судлалын тухай” (*On Manchu Studies in the PRS, 1980-81*) гэдэг нийтлэл нь ч өмнөхөөсөө дутахааргүй үнэ цэнэтэй бүтээл болсон юм. Учир нь Европд урьд өмнө нь энэ тухай багахан мэддэг байсан юм.

Герман, Итали хоёр хэлээр бүтээлээ туурвидаг Италийн судлаач Ж.Стари (*G.Stary*) Манж судлалын бүхий л сэдвээр асар олон тооны ном, өгүүлэл нийтлүүлсэн юм. Энэхүү богино өгүүлэлд түүний бүтээлийн тоймыг ч дурдах аргагүй. Цөөн хэдийг дурдвал тэрээр “Манж судлалын өнөөгийн байдал ба хийгдэх судалгаанууд” (*The Present State of Manchu studies and Work still to be done, 1979*) хэмээх хөтөлбөр болохуйц өгүүлэл бичжээ.

Түүнчлэн “Итали ба Ватикан дахь Манж судлалын бүтээл” (*Manchu works in Italy and in the Vatican 1985*) гэдэг судалгааны үнэт бүтээлээ нийтэлсэн. Мөн үүний зэрэгцээ Орос, Хятадын харилцааны талаар “Орос Хятадын эртний харилцаа” (*The Earliest Relations between Russia and China, 1974*) болон “Хятадыг анхны элчүүд Орост зорчсон” (*China’s First Envoys to Russia 1976*) нэртэй 2 ном бичсэн юм. Түүний өөр хоёр бүтээл нь Манжийн уугуул шашин болон нийтийн уран зохиолын тухай “Манж удган доод ертөнцөд аялсан нь” (*A Journey to the under world of Manchu Shamaness 1977*) ба “Нэг зуун хорин өвгөний өгүүлэл” (*Tales of 120 old men 1983*) юм. Мөн манж дуу найраглалын тухай “Манжийн уран зохиолын шинэ хэрэглэгдэхүүн” (*New Materials for the Manchu Literature*), “Манж Хятад холимог найраглал” (*Manchu Chinese Mixed Poems 1985*) зэргийг дурдаж болно.

Ж.Стари (*G.Stary*) бас Манжийн амьд соёл, уран зохиолыг сонирхож хүнд бэрх замаар мөрдөн замнаж бичиж туурвисаар байна. “Манж сонин, сэтгүүл” (*Manchu Journals and Newspapers 1989*) хэмээх өгүүлэл нь чухам түүний энэхүү сонирголоос үүдэлтэй юм. Түүнээс гадна тэр 1981 онд Жин Чизун (*Jin Qizong*)-ийн хянан хэвлүүлсэн “Турван өрхийн тосгоны Манж нарын амьдрал ба түүх” (*The life and History of the Manchu in the village of Three Families 1984*)-ийг Хятадын хагас албан тоймын тайлбартай орчуулгыг хийжээ. Хожим нь мөн “Шивээ Манжийн түүх” (*History of the Sibe-Manchus 1985*) номоо туурвисан байна. Хятадын Хар мөрөн мужид 2-3 мянган Манж хэлтэн аж төрж байгаа хэдий ч Хятадын Туркстаны баруун хойд нутгийн зах Илийн районд аж төрдөг Шивээ омогт 83600 хүн байдгийн 15 мянга нь Манж хэлний нэгэн нутгийн аялгуугаар ярьж байна. Сүүлийн хорь гучин жилийн хугацаанд тэдний хэлийг сонирхон судлах явдал ихэд өсч байна.

Европт Ж.Стари (*G.Stary*)-аас гадна Польшийн хэл шинжээч эрдэмтэн С.Калужинский (*S.Kaluzynski*) энэ салбарт нилээд судалгаа хийсэн байна. Тэрээр хэд хэдэн өгүүлэл бичсний дээр “Кулдша нутгийн Шивээ Манж омгийнхны хэл яриа” (*The language of the Sibe Manchu Tribe from the Territory of Kuldsha 1977*) хэмээх ном хэвлүүлжээ.

Өнөөгийн Манж хэлийг Манжийн үеийн бичгийн хэлтэй харьцуулан судлах явдал Манж судлалд бүхэлд нь шинэ далайц нэмэх болно.

Оросын эрдэмтэн С.М.Широкогов (*S.M.Sirokogov*)-ын буулгасан “Тэбүталин бичиг” (*Book Tebutalin*) хэмээх Манжийн үндэсний тууль энэ их эрдэмтнийг 1937 онд нас барсны дараа алга болсон ба хураангуйлсан хувилбар нь 1960-аад оны үед Хятадын соёлын хувьсгалын үеэр устгагдсан нь маш харамсалтай хэрэг болсон ч зарим хэсгийг нь 1983 онд М. Гимм хальсанд бичиж авсан байна.

Хэтийн төлөв

Манж судлалд үндсэн хоёр төлөв байдаг. Манж хэл өөрөө багтдаг Тунгус хэлний шинжлэлтэй холбоотой байдгаас гадна Манж Хятад хүмүүс олон зуун жил хамт аж төрж ирсэн учир Манж судлал нь Хятад судлалтай нэн ойр нягт холбоотой байдаг.

Энэ хоёр төлөв хэзээд ч байх нь ямар ч эргэлзээгүй юм. Хэрвээ нэгэн өдөр үлэмж их хэмжээний учир шалтгаан гарч ирвэл энэ нь Манж судлалд хоёр үндсэн зарчим үүсгэж болох ч энэ хоёр мөн л бие биеэсээ харилцан үл сална. Европын Манж судлалын үүднээс авч үзвэл энэхүү үлэмж ялгаатай өөрчлөлт Манж судлаачдын үзэл бодол анхааралд их зүйлийг авч ирэх болно.

Япон, Солонгос, Тайваньд манж судлал маш өндөр хөгжсөн ба сүүлийн үед Хятадад нэлээн сайжирч байна. Иймд энэ салбарт Европын судлаачдад ихээхэн бэрхшээлтэй болж байгаа ч Манж судлалын талаар дэлхий нийтэд хэвлэн нийтлэгдсэн мэдээллийг нэгэн зэрэг цуглуулах боломжтой болж байгаа нь маш чухал ач холбогдолтой юм.

Энэ зөвхөн жинхэнэ эх сурвалжийг төдийгүй дам эх сурвалжийг цуглуулах нь чухал ач холбогдолтойг харуулж байна. Энэ нь хоёр хэлбэртэй. Нэг хэсэг нь судалгааны зөвхөн тодорхой нэг хэсгийг сонгох, шинжлэн судлахыг зорьж байхад, нөгөө хэсэг нь бүрэн төгс бүтээл гаргахыг зорих жишээтэй юм.

Эхний хэсэгт тухайлбал Б.К.Пасков (*B.K.Paskov*)-ийн “Манж хэл болон уран зохиолыг судлахад Оросын эрдэмтдийн оруулсан хувь нэмэр” (*The Contribution of Russian Scholars to the study of Manchu language and Literature, 1956*) болон Х.Франк

(H.Franke)-ийн “Германы их сургуулиуд дахь Хятад судлал” (*Manchu studies in Germany to his Sinology at German Universities, 1968*) бүтээлийн “Герман дахь Манж судлал” хэмээх хавсралт зэрэг хамаарагдана.

Сүүлийн хэсгийн хамгийн сонгодог жишээ бол Мацура Шигэру (*Matsuura Shigeru*) – гийн туурвисан “Манж- Шивээ хэлний бүтээлүүдийн ном зүй” (*A Bibliography of works on the Manchu and Sibo language, 1980*)/in *Memories of the Reseach department of the Toyo Bunko, 1980*/ юм.

Гэвч өнөөгийн нөхцөлд хамгийн сайн, төдийгүй хамгийн бүрэн төгс болсон нь Ж. Стари (*G. Stary*)-гийн “Манж судлалын олон улсын ном зүй” (*Manchu Studies An International Bibliography, Weisbaden, 1990*) хэмээх бүтээл юм. Энэхүү бүтээл нь манж судлалын талаар бүх хэл дээр гарсан өгүүлэл, номыг (үүнд *угсаатны зүй, түүх, хэл, уран зохиол, түүнчлэн холбогдох хэлүүд болох Жүрчин, Манж, Шивээ хэлнүүдийн талаар гарсан бүх номууд*) тоочин бичсэнээс гадна Зүүн Азийн сэтгүүлүүдийн индекс, цуглуулга, зохиогчдыг нь багтаан оруулснаараа маш чухал ач холбогдолтой болсон юм.

Уг номд орсон бүх гарчгуудыг тухайн хэлээр (орос хэл дээр бичигдсэн эхийг латин үсгээр, зүүн Азид хэвлэсэн эхийг хятад үсгээр галигласан) бичиж англиар орчуулан тавьжээ. Иймийн учир энэ ном ‘олон улсын’ гэсэн алдар цолыг зүй ёсоор авч байгаа юм.

Манж судлалын ач холбогдол 19 зууны эцсээр Хятад дах манжийн дарангуйлал суларч эхлэх үеэс буурч эхэлсэн байна.

Энэ нь Ж. Эдкин (*J. Edkin*)-ий дэвшүүлсэн “Юуны учир манжийг судлах вэ” (*Why study Manchu, 1898-99*) гэсэн хэлэлцүүлгээр эхэлсэн ба энэ асуудал гурван арван жилийн турш эрдэмтэдийн дунд яригдсаар эцсийн дүнд Э. Хауэр (*E. Hauer*)-ын “Хятад судлал яагаад манжийг судлах ёстой юм бэ” (*Why the sinology should study Manchu, 1930*) гэсэн өгүүлэл хүртэл бичсэн юм. Эдгээр судлалыг ирээдүйд Европт хэрхэн үнэлэхийг урьдчилан таахад бэрх юм.

Т. Отгонтуул. /МУИС. МХСС. Эх бичиг Алтай судлалын тэнхим/